

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН МАХНЫН ТҮМТИЙН  
Удирдах зөвлөлийн 2020 оны 06 дүгээр сарын 23-ны  
өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлав.



**2020-2024 ОНЫ ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ "МАХН"-ЫН ГОВЬ-АЛТАЙ  
АЙМГИЙН ТҮМТИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**ИРГЭДЭЭР ОВОГЛОСОН, ИРГЭДИЙН ТӨЛӨӨ “ЭРҮҮЛ ХОТ” ХӨТӨЛБӨР**

**Зорилго:**


Говь-Алтай аймаг болон орон нутгийн иргэдийнхээ ашиг, сонирхлыг удирдлага болгож, ардчилал, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан экологийн чиг баримжаатай нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгон эрүүл аюулгүй хотод амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Монгол хүн бүр эрүүл аюулгүй амьдрах эрхийг дээдлэж орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана.
- Аймгийн иргэн бүрийн эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээний зардлыг төрийн өмчийн эмнэлэгээр үйлчлүүлэхэд төр засгаас бүрэн хариуцаж иргэд эрүүл мэндээ хамгаалуулах эрхээ бүрэн эдлэх,
- Иргэдээ ажлын байраар хангах, орлогын найдвартай эх үүсвэртэй болгох,
- Иргэдийн авах цалин амьдралд нь хүрэлцэхүйц байх, хөдөлмөрийн хөлсөөрөө сайхан амьдрах боломжийг бүрдүүлэх,
- Ядууралд өртсөн иргэдээ “Хүрэлцэхүйц орлого”-той болгох, ядуурлыг бүрмөсөн арилгах,
- Төр засгийн бүх шатны байгууллагуудыг авилгаас цэвэрлэх,

Орон нутгийн төр засгийн байгууллага, албан тушаалтнууд хариуцлага хүлээдэггүй өнөөгийн гаж тогтолцоог халж Монгол хүнийг хамгаалдаг иргэндээ ээлтэй нутгийн захиргааны шинэ тогтолцоонд шилжинэ.

“МАХН” нь эх оронч үзэлтэй мянга мянган шударга иргэдийн ирүүлсэн экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн хөгжлийн өнөөгийн дүр төрхийг дүгнэсэн, улс эх орныхоо хөгжлийг хурдасгах өргөн хүрээтэй шийдвэртэй алхмуудыг санал болгож байна.

Хөтөлбөрийн хүрээнд: ХОТЫН ИРГЭН -НОГООН СОЁЛ ИРГЭНШИЛ дэд хэсэгт экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн асуудлаас бүрдсэн хоорондоо харилцан хамааралтай хүн төвтэй хөгжлийн бодлогыг бий болгоно.



5217144139  
ДК 48060 0018301

## НЭГ. ИРГЭН ТАНЫ АМЬДРАЛД:


Иргэн та нас, хүйс, шашин шүтлэг, намын харьялал, угсаа гарал, оршин амьдарч буй газар, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр эрхэм чанараа мэдрэн, айх аюулгүй, эрх чөлөөтэй Эрүүл хотод амьдран, сурч боловсрох эрхтэй.

- 1.1 Төрийн болон хувийн хэвшлийн салбарт нас, хүйс, зүс царайгаар ялгаварлан гадуурхахыг зогсоох,
- 1.2 “Монгол хүн-Оюунлаг иргэд” төлөвшүүлэх зорилгоор хүүхэд бүр амьдралын түвшинээс үл хамааран цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн болон Их дээд сургуульд суралцах тэгш боломжийг бүрдүүлнэ,
- 1.3 Хүүхэд хамгаалах төв, хөгжлийн бэхшээлтэй хүүхдийн өдөр өнжүүлэх , асрамжийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлж, шаардлагатай тохижилт үйлчилгээг хийлгэх
- 1.4 Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээний чанартай, тэгш, хүртээмжтэй байдлыг хангаж, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүнийг хөгжүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд анхаарна.
- 1.5 Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих зорилгоор иргэд биенийн тамирыг хүн бүрийн амьдралын эрүүл дадал нөхцөл бололцоог нээхийн зэрэгцээ “ЭРҮҮЛ ЗӨВ АМЬДРАЛ”, “ЗӨВ ХҮНС” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

## ХОЁР. ӨРХ, ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛД:

Монгол Улсын тулгуур баялаг нь “Монгол өрх” мөн тул аймаг ,сумын төвүүдэд амьдарч буй өрх гэр, залуу гэр бүл, иргэдийг тохилог орон сууцанд амьдрах бодлогыг боловсруулан, өрх бүрийг орон сууцаар хангах зорилт тавьж ажиллана.

- 2.1 Аймгийн төв, сумдад хувийн орон сууц барих бодлогыг дэмжин ажиллана.
- 2.2 Бичил болон өрхийн бизнесийг дэмжих талаар Сум, орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрт иргэн бүр тэгш хүртээмжтэй хамрагдах боломжийг бий болгоно.
- 2.3 Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих санхүү, зээлийн төвүүдийг дэмжих зэрэг зорилтот бичил банк, санхүүгийн байгууллага байгуулж, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгосноор айл өрх, аж  ахуйн нэгжийн орлого, бизнесийн боломжийг нэмэгдүүлж, ажлын байрыг шинээр бий болгоно.




## ГУРАВ. АЙМАГ, СУМЫН ХҮРЭЭНД:

- 3.1 Алтай хотын агаарын болон хөрсний бохирдол, орчны бохирдол, дэд бүтцийн асуудлыг цогцоор шийдвэрлэн цэвэр агаар, эрүүл хөрс, ногоон байгууламж бүхий экологийн тэнцвэртэй орчныг бурдүүлэх
- 3.2 Залуучуудад зориулсан гарааны бизнесийг дэмжих “Старт апп” хөтөлбөрийг хэрэгжүүлж, бизнес эрхлэгч залуучуудад зориулсан “Дундын оффис” сум бүрт байгуулах,
- 3.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдэд зориулсан уян хатан ажиллах ажлын байр олноор бий болгох,
- 3.4 Ахмадуудын зөвлөгөөг салбар бүрт хүргэхэд анхаарч, байнга хамтран ажиллана.
- 3.5 Аймаг, сумын нутгийн ногоон орчин, гол ус бүхий орчинд иргэдийн оролцоотой байгальд ээлтэй Эко сум хөтөлбөр хэрэгжүүлэх,
- 3.6 Иргэд амьдрах таатай эрүүл цэвэр, ногоон технологи бүхий хаягдалгүй орчинг иргэдийн оролцоотойгоор бурдүүлэх,
- 3.7 Аймаг, сумын төвүүдэд Төр хувийн хэвшлийн оролцоотой хүүхэд, залуучуудын хөгжих орчин нөхцлийг бүрдүүлсэн цэнгэлдэх хүрээлэн, клубууд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийг дэмжиж ажиллах,
- 3.8 Аймаг, сумын төвүүдэд хөдөө аж ахуйн бүтээгдхүүн, малын гаралтай нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж хөгжүүлэх эрх зүйн өөрчлөлтийг хийх,
- 3.9 Хүнсний аюулгүй байдлыг ханганд, малын гаралтай эцсийн бүтээгдэхүүнийг экспортлон малчдын орлогыг төрөлжүүлэн нэмэгдүүлэх зорилгоор малыг эрүүлжүүлэх аяныг өрнүүлэх,
- 3.10 Зах зээлийн мэдрэмжтэй, хөрвөх чадвар сайтай, зохистой сургийн, малжуулах зээлийг төр-арилжааны банкны хамтын ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлж, зээлийн дарамтнаас малчдыг чөлөөлөх боломжийг бурдүүлэх,
- 3.11 Сумдад “Цагаан алт” болох ноосыг боловсруулах, жижиг дунд үйлдвэрийг дэмжих,
- 3.12 Алслагдсан сумдын бэлчээрийг худаг усаар хангахад орон нутагаас дэмжилэг үзүүлэх ,
- 3.13 Орон нутгийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх, иргэдэд хууль эрх зүй, удирдлагын туслалцаа үзүүлэх, боловсон хүчний асуудал, бус нутгийн MCYT боловсон хүчний сургалт дадлагажилтыг шийдвэрлэх, дэмжиж ажиллах,
- 3.14 Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг нэмэгдүүлэн хүүхдэд ээлтэй ногоон орчин бурдүүлэх бодлогыг дэмжиж хэрэгжүүлэх,
- 3.15 “Эрүүл зөв амьдрал”, “Зөв хүнс” хөтөлбөрийг нэн тэргүүнд цэцэрлэг, сургууль, олон нийтийн үйлчилгээний газруудад нэн тэргүүнд хэрэгжүүлэх,

санхүүжүүлэх зорилгоор аймаг, сумын засаг даргын дэргэд “Багш” сан байгууллан ажиллуулах,

3.17 Сумдын иргэдийн мэдээлэл, харилцаа холбоог сайжруулна.



МАХН-ЫН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТҮМТ

